



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
ерөнхий газрын 2025 оны худалдан авах
ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт
оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11, 2.12.2, 3.11-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны А/19 дүгээр тушаалаар баталсан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-д хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулсугай.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг зохих журмын дагуу цахим системд бүртгүүлэхийг Хуулийн хэлтэс (Д.Орхонтуул)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 8/10 дугаар тушаалын хавсралт



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Д/д	ТШ код	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	ТШ төрөл	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг /мян.төг/	Тухайн онд санхүүжих дүн /мян.төг/	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга	Тендер зарлах огноо	Гэрээ байгуулах эрх олгох огноо	Гэрээ дуусгавар болгох, дүгнэх огноо
23	ГЗБГЗЗЕГ/20250103025	Байгууллагуудад зориулсан лавлагаа, мэдэгдэл хүргүүлэх, зарлан мэдээлэх, нийлүүлэгч байгууллагуудын ачаалал тэнцвэржүүлэх хөгжүүлэлтийн ажил	Үйлчилгээ	Урсгал төсөв	127,500.0	127,500.0	Нээлттэй тендер шалгаруулалт	2025.04.24	2025.05.13	2025.11.12
23	ГЗБГЗЗЕГ/20250102032	Архивын тоног төхөөрөмж, эд хогшлын худалдан авалт (салбарын хэмжээнд)	Бараа	Урсгал төсөв	200,000.0	200,000.0	Нээлттэй тендер шалгаруулалт	2025.03.28	2025.05.31	2025.11.12